



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/66

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн салбарт хийгдсэн инноваци  
шингэсэн бүтээгдэхүүний тухай

Монгол Улсын Засгийн Газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Инновацийн тухай хуулийн 17.1.8, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-ын 2.2.3-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн салбарт Эрүүл мэндийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны захиалга, Шинжлэх ухаан технологийн сангийн санхүүжилтээр хийгдсэн инноваци шингэсэн бүтээгдэхүүний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Жагсаалтад дурьдагдсан эрдэмтдийн бүтээлийг үйлвэрлэл, хэрэглээнд нэвтрүүлэхэд холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Эм, үйлдвэрлэл технологийн газар /Л.Мөнхтулга/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д үүрэг болгосугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

080234





6	Байгалийн гаралтай зарим эмийн бэлдмэлийг эмнэлзүйн практикт бүрэн нэвтрүүлэх	Салимон 50 мл /шингэн/	2011	2014	БСШУСЯ	Шинэ анагаах ухаан дээд сургууль	Дархлаа сэргээх бэлдмэл	М.Амбага	Патент № 2031 2002.09.27 Барааны тэмдгийн гэрчилгээ № 9164 2011.06.17 Эмийн бүртгэлийн № L150325LO04470
7	Байгалийн гаралтай зарим эмийн бэлдмэлийг эмнэлзүйн практикт бүрэн нэвтрүүлэх	Хоффитас 0.5 г /үрэл/	2011	2014	БСШУСЯ	Шинэ анагаах ухаан дээд сургууль	Элэгний өөхлөлт, чихрийн шижин	М.Амбага	Барааны тэмдгийн гэрчилгээ № 9537 2011.06.17 Биологийн идэвхт бүтээгдэхүүн бүртгэлийн дугаар № L20150930PH00807
8	Кальци 200 капсул	Кальци 200 /капсул/	2010	2013	БСШУСЯ	Монхимиио ХХК	Ясны нягтыг нэмэгдүүлэх, кальцийн дутагдалаас урьдчилан сэргийлэх биологийн идэвхт бүтээгдэхүүн	Д.Дэмбэрэлнямба	Патент № 2031 2002.09.27 Барааны тэмдгийн гэрчилгээ, № 9164 2011.06.17 Эмийн бүртгэлийн № L150325LO04470
9	Картил 200 гр нунтаг	Картил 200 гр /нунтаг/	2010	2013	БСШУСЯ	Монхимиио ХХК	Үе хоорондын зөөлөн эдийг нөхөн төлжүүлэх, үений шингэн нөхөх биологийн идэвхт бүтээгдэхүүн	Д.Дэмбэрэлнямба	Патент № 2042 2002.09.27 Барааны тэмдгийн гэрчилгээ № 9165 2011.06.17, Эмийн бүртгэлийн № L150325LO04471
10	Галзуу өвчний эсрэг өвөрмөц иммуноглобулин	Имуноглобулин /ампул/	2011	2013	БСШУСЯ	НЭМҮТ	Сэжигтэй амьтанд хазуулсан тохиолдолд тарьж хэрэглэнэ.	Д.Дандий	Патент №2901
11	Альбумин үйлдвэрлэх дэвшилтэт технологи	Альбумин /ампул/	1991	1992	БСШУСЯ	НЭМҮТ	Цусны уургийн бэлдмэл	Д.Дандий	Патент №3784

12	Меланодермин ДОЦ бэлдмэлийг үйлдвэр практикт цогцоор нэвтрүүлэх	Мелагенин /тосон түрхлэг/	2014	2016	БСШУЯ	Монсерум ХХК	Арьс цайх буюу арьсны нөсөө алдагдах мөн янз бүрийн түлэгдэлээс үүссэн арьсны депигментацийн үед ПУВА аппараттай хослуулан гадуур хэрэглэнэ.	Д.Дандий	Патент №2857 /2007-07-26/
13	Молекул биологийн үндсэн хоёр эсгийг шинээр нийлэгдэн үйлдвэрлэж лабораторийн үйлчилгээнд нэвтрүүлэх туршилт судалгаа, технологи	Халдварт болон халдварт бус өвчин, удмын өвчнийг оношлох оношлуурт орох бүрэлдэхүүн	2014	2016	БСШУЯ	Чорос-Онош ХХК	Халдварт болон халдварт бус өвчин, удмын өвчнийг оношлох оношлуурт орох бүрэлдэхүүн	Ж.Зандраа	Патенттай
14	Монголын уламжлалт эм эмнэлэг	Стериалафитин /нунтаг/	1994	1996	ЭМЯ	Уламжлалт анагаах ухаан технологийн хүрээлэн	Цэр ховхлох, ханиалга намдаах	Б.Дагвацэрэн	Патенттай /худалдаанд гарсан/
15	Монголын уламжлалт эм эмнэлэг	Асваргал /нунтаг/	1994	1996	ЭМЯ	Уламжлалт анагаах ухаан технологийн хүрээлэн	Зүрхний үйл ажиллагааг дэмжих, хэм алдагдалд хэрэглэнэ.	Б.Дагвацэрэн	Патенттай /худалдаанд гарсан/
16	Уламжлалт нийлмэл жорын найрлагад суурилсан биологийн идэвхит 21 нэрийн бэлдмэлийн эмнэл зүй, стандарт, технологийг нэвтрүүлэх нь	Бибилэн-3 /нунтаг/	2010	2013	БСШУСЯ	Уламжлалт анагаах ухаан технологийн хүрээлэн	Холестрин бууруулах, тархины цус хомсролоос сэргийлэх үйлдэлтэй	Ц.Чимэдрагчаа	Патенттай /худалдаанд гарсан/